# 1000 НОМ

УНШЛАГЫН ХӨТӨЛБӨР

Боловсруулсан: Нэпко Кидс хэвлэлийн газар | 2023 он

www.nepkokids.mn

**1** 3 нас — 17 нас **780**

**долоо хоног** — **долоо хоног**

**3–18**
нас хүртэл

**7 хоног**
бүр 1–2 ном

**780 долоо хоногт**
1000 ном

# ЖИЛД НЭГ ХҮҮХЭД 67 НОМ

**5-Р** ДОЛОО ХОНОГ




Өөрийн мэдрэмжийг нээлттэй илэрхийлж бусдын мэдрэмжийг ойлгох хүлээн зөвшөөрөхийн ач холбогдлыг таниулна.

**52-Р** ДОЛОО ХОНОГ



Унгах нь хэвийнзүйл бөгөөд ичээд, зовниод байлгүй, харин хаана гаргахаа зохицуулж сурах хэрэгтэй тухай.

**111-Р** ДОЛОО ХОНОГ




Эрүүл хүнийг бий болгоход амьдралын зөв хэвшлийг багаас нь эзэмшүүлэхэд юу, юу чухал болох тухай

**163-Р** ДОЛОО ХОНОГ




Энэхүү зохиолд Алекс бусдын уйтгартай, гунигтай, сэтгэл гонсгор байдлаас хараад мэднихдэг.

**215-Р** ДОЛОО ХОНОГ




Итгэлтэй оролдлоготой байх, сандралаа давж тайван байх зэрэг зоригийн чанарыг эзэмших

**267-Р** ДОЛОО ХОНОГ



Үе тэнгийн дээрэлхэлтийн хэлбэрүүдийг үлгэрээр дамжуулж ойлгуулсан

**319-Р** ДОЛОО ХОНОГ




Хайртай хүнээ алдсан үед сэтгэл санаагаа хэрхэн тайвшруулах аргыг үлгэрээр дамжуулж таниулсан

**423-Р** ДОЛОО ХОНОГ




Дэлгэцийн хамаарал биднэд болон ойр дотны хүмүүст ямар нөлөө үзүүлдгийг харуулсан.

**527-Р** ДОЛОО ХОНОГ




Кодчилолын суурь мэдлэгийг сонирхолтой дасгал даалгавраар баяжуулан бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж медиа бүтээлийн сантай болох боломжоор хангана.

**631-Р** ДОЛОО ХОНОГ




Хэн нэгнийг шохоорхох, татагдах нь хэвийн зүйл бөгөөд хэрхэн даван туулах вэ? гэсэн асуултад хариулт өгнө.

**735-Р** ДОЛОО ХОНОГ




Олон улсын их дээд сургуулиудад өргөдөл гаргах, тэтгэлэгт хамрагдах зэрэгт шаардагдах академик эссэ бичих арга барилд суралцана.

NEPKO Kids

14 орны
**150**
гаруй ном

**20**
орчим зохиолч, зураач

2018
NEPKO publishing

2019
COLORS 2019 OF ULAANBAATAR

2020
Next Page
FOXBOX

2021
Magic Box
Andersen academy

2022
Mega Mind
LEARN TO LEARN

2023
LOUD LIBRARY
Номын Синдромтой Анги
OXFORD THINKERS

# ЗААВАР




100% COTTON
COLD WASH SEPERATELY
LOW LRON BLEACH
DRY CLDAN ONLY
DO NOT BLEACH
DO NOT BLEECH
30°





# УНШИЖ, ОЙЛГОХ ЧАДВАР...

## МОНГОЛЫН КЭЙС

**195** сургуулийн **6 999** сурагчаас судалгаа авсан

**Уншиж ойлгох чадвар Олон улсын дунджаас маш доогуур үнэлэгдсэн**

## УНШИЖ, ОЙЛГОХ ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ

| 475 | 525 | 378 |
|---|---|---|
| Олон улсын дундаж | Тэргүүлэгч Сингапур | Монголын авсан үнэлгээ |

ОЛОН УЛСЫН СУДАЛГАА

# УНШИХ ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ **ЦОГЦ ШИЙДЭЛ**

Хүүхдийг номонд дурлуулж, **"мэргэжлийн уншигч"** болох чиглүүлэх бидний санал болгож буй **"Насанд хүрэхээс өмнө заавал унших 1000 ном" у**ншлагын хөтөлбөр нь Оксфордын Их сургуулийн уншлагын хөтөлбөрөөс жишээлсэн, сургуулийн өмнөх **3–5 настнууд** болон ЕБС-ийн **6–18 насны** сурагчдад зориулан, нас насны ангиллаар хүүхдийн тухайн насанд олж авбал зохих мэдлэг, чадварыг тусгасан **18 нас хүртэл** унших **1000 номыг** багтаасан цогц хөтөлбөр юм.



## ХӨТӨЛБӨР

- 1000 ном
- Гарын авлага
- Багшийн сургалт
- Үнэлгээ
- Онлайн дэмжлэг

## ХӨТӨЛБӨРИЙН 1000 НОМЫН **АГУУЛГА, СЭДВИЙН ХАМРАХ ХҮРЭЭ**

ЕБС-ийн хичээлийн агуулгад хангалттай тусгагдаагүй, албан бус боловсролын хүрээнд олговол зохих сэдэв, агуулгыг хүүхдийн насны онцлогт тохируулан шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлж гаргасан.

**Монгол ёс уламжлал, түүх**

**Амьдрах ур чадвар**

**Бие сэтгэцийн эрүүл мэнд**

**Санхүүгийн боловсрол**

**Хувь хүний хөгжил**

**Хүрээлэн буй орчин**

**Ялгаатай байдал**

**Нийгмийн харилцаа**

**Урлаг, гоо зүй**

**Ерөнхий мэдлэг**

## ГАРЫН АВЛАГА

Нэпко Кидс хэвлэлийн газар уншлагын хөтөлбөрт санал болгож буй номуудын сонголтыг хийхдээ агуулга, төрөл, сэдвийн хувьд өргөн хүрээг хамруулахыг зорьсон бөгөөд тухайн ном нь АНУ-ын Сэтгэл судлаач Ховард Гарднерийн боловсруулсан Олон оюуны онолд дурдсан найман оюуныг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж байгаа эсэхийг харгалзсан.

Багшийн гүйцэтгэх ажлыг хөнгөвчилж, дээр дурдсан стандартаар уншлагад ашиглах ном тус бүрд гарын авлага боловсруулсан болно. Багш уг гарын авлагыг өөрийн арга барил, сурагчдын онцлог, ялгаатай байдалд тохируулан өөрчлөх боломжтой.

*Номын ерөнхий мэдээлэл, зураг бичвэрийн онцлог*

### Мангасуудад ч бас мэдрэмж бий




Уншлагын түвшин: C
Зохиолч, зураач: **Өзлэм Фэдай Коржак**
Хуудасны тоо: 32
Үгийн тоо: 150
Нас: 3+
Төрөл: **Зурагт ном**

**Зураг, бичвэрийн онцлог:**
- Зургаар бичвэрийн агуулгыг дэлгэрүүлэн харуулсан
- Бичвэрт аман ярианы элемент багтсан
- Мэдрэмжүүдийг зургаар тод, томруун гаргасан

**Уншлага хийхэд өгөх зөвлөмж:**
- Бүлгээр уншлага хийхэд тохиромжтой
- Хүүхдүүдэд зургийн дүрслэлийг үгээр илэрхийлэх боломж олгох
- Дуу авиаг дуурайн үзүүлэх

**Олон давтагдсан үг:**
мангас, сэтгэл хөдлөл, мэдрэмж, ичих, уйлах, уйдах, баярлах, гуниглах, айх, эргэлзэх, бахархах, уурлах, хайрлах

Үндсэн агуулга (мессеж): Үлгэрт гардаг хүмүүсийг айлгадаг мангасуудад ч сэтгэл хөдлөл, мэдрэмж байдгийг өгүүлсэн, хүүхдэд бусдыг ойлгуулахыг зорьсон зохиол.

Уг зохиолд мангасууд өөрсдийг нь хүмүүс үзэн яддаг байдлыг эсэргүүцэж, дуу хоолойгоо хүргэн, өөрсдийн мэдрэмжүүдээ илэрхийлэхийн хамт хүн төрөлхтөнтэй найрамдах, эвсэх агуулгыг олж харна.

**УНШИХЫН ӨМНӨХ БЭЛТГЭЛ**

- ***Ерөнхий санаа, үгийг нээлттэй асуулт хэлбэрээр асуух***
  - Мангасууд аймшигтай юу?
  - Мангас ямар хэлбэр, дүрстэй байдаг юм бол?
- ***Хүүхдийн туршлагыг үлгэрийн агуулга, үгийн сантай холбох***
  - Номыг барьж, хүүхдүүдэд харуулан, анхаарлыг хандуулах.
  - Гарчгийг унших: "Мангасуудад ч бас мэдрэмж бий".
  - Энэ үлгэр юуны тухай, юу гарах бол гэж зохиолыг хүүхдүүдээр таалгах.
  - Хүүхдүүдэд номоо тараан өгч, зургийг ажиглан харах хугацаа өгөх
  - Мангасаас айдаг эсэхийг асуух

22

*Номын бичвэрт дурдагдаагүй байж болох номоор дамжуулан хүргэх гэсэн далд мессеж, агуулга*

*Чиглүүлэгтэй уншлагын эхний шат болох Уншихын өмнөх бэлтгэлийг хэрхэн хангах зөвлөмж*

*Номыг унших явцад хүүхдүүдтэй ярилцаж, хэлэлцүүлэг өрнүүлэх зөвлөмж, санаа*

## УНШИХ ЯВЦАД

***Багш номын хуудсыг нээж, хүүхдүүдэд хэн энэ зохиолыг бичиж, хэн зургийг зурсныг хэлнэ***

***Уншлага хийх***

- Номын эхний хэсэгт мангасууд эсэргүүцлээ илэрхийлж буй хэсэг гарна. Энэ хэсгийг жүжиглэлттэй, авиаг дуурайн, сонирхолтой байдлаар хүүхдүүдэд уншиж өгнө.
- Унших явцад хүүхдүүдээс зураг дээр юу дүрсэлснийг асууж болно.
- Эсэргүүцэлтэй хэсгийг уншсаны дараа түр зогсоод дараах асуултыг асууж болно:
  - Мангасууд эсэргүүцлээ илэрхийлэхдээ юу гэж хэлсэн бэ?
  - Тэдэнд хүмүүс яагаад дургүй гэж бодож байна?
- ***Мангасууд өөрсдийгөө ямар мэдрэмжтэй болохыг тайлбарласан хэсгийг уншина***:
  - Харагдах дүр нь айлгамаар байсан ч тэдэнд бас ямар онцлог чанарууд байна вэ?
  - Тэдэнд хүнд байдаг шиг сэтгэл хөдлөлүүдү байж уу?
  - Чиглүүлэх асуулт өгнө: Бие нь сайнгүй үедээ мангасууд яадаг гэж байна? (Уйлдаг...)
- Мангасууд ямар сэтгэл хөдлөл гаргадаг гэж байна? Ярилцах
  - Гуниглдаг, уйддаг, ичдэг, догдолдог, айдаг, будилдаг, догь байдаг, баярладаг, уурладаг гэсэн 9 сэтгэл хөдлөлтэй 9 мангасыг хуудсаа эргүүлэн, олох
  - Ямар байдалд тэд гомдсон бэ? Та нар ямар үед гомддог вэ? Бүдүүлэг гэж юу гэсэн үг вэ? гэхчлэн сэтгэл хөдлөл бүр дээр ярилцана.
- Зохиолын төгсгөлд мангасууд биднийг ч гэсэн хайрлаач, тэврэлдэцгээе гэдэг. Хайраа илэрхийлэн аав, ээжийгээ, ах эгчийгээ, дүүгээ, найзыгаа тэврэч болохыг ярилцах.

## УНШСАНЫ ДАРАА

- Хүүхдүүд зохиолыг уншихын өмнө хэлж байсан таамаг хэр зөв байсныг ярих.
- Дараах асуултаас асууж, ярилцах:
  - Мангасууд яагаад эсэргүүцэл илэрхийлэхээр шийдсэн билээ?
  - Мангасуудад ямар ямар сайн чанар байсан бэ?
  - Мангасуудын дүрүүд хаана гардаг вэ?
  - Та нар мангасаас одоо айх уу? Яагаад?
- Зохиолд хэдэн мангас гарсан бэ? (Тоолоорой)
- Энэ мангасууд ямар ямар онцлогтой билээ? (Номын хамгийн арын хуудсан дээрх зургийг харж ярина)

23

*Номыг уншсаны дараа хүүхдүүдтэй хэлэлцэх, ярилцах сэдэв, зөвлөмж*

*Номын агуулгыг батамгахын зэрэгцээ, бичвэрт дурдаагүй далд мессежийг ойлгуулж, ярилцах асуулт, зөвлөмж*

*Номын агуулга, мессежийн бусад хичээлтэй уялдах холбоо*

## ХОЁР ДАХЬ УНШЛАГА

- Номын зургийг ашиглан хүүхдүүд нэг нэгэндээ номын тухай ярьж өгнө.
- Хүүхдүүдийн ойлголтыг үнэлэх:
  - Найздаа номоо ярьж өгч байгааг ажиглах.
- Хүүхдүүдийн ойлголтыг бататган, дараах агуулгыг ойлгуулан ярилцах:
  - Харагдах дүр төрх нь аймшигтай, зэвүүн байж болович сэтгэл зүрх нь бусдын төлөө, үнэнч, тусч зэрэг чанарууд нь нуугдсан байх магадлалтай тул гадаад үзэмжээр бүү дүгнэж, хандаарай гэдгийг хүүхдүүдэд ойлгуулахаар жишээгээр тодруулж тайлбарлаарай.
  - Би царай муутай, бие галбир тааруу гэж өөрийгөө голохгүй, би ийм чадвартай, хүн чанартай гэдгээ үйл хөдлөлөөр харуулахад бусад нөхөд чинь чамаар бахархана гэж өөрт нь итгэл төрүүлээрэй.
  - Зохиолд дурдагдаагүй өөр ямар ямар мэдрэмж байдгийг ярилцах. Тийм мэдрэмж ямар үед төрдгийг ярилцах. (Жишээ нь: даалгавраа хийгээгүй үедээ санаа зовних, айх г.м.)

### Бусад хичээлтэй уялдах нь

**Нийгмийн ухаан:** Хүүхдүүдийн эмпати чадварыг хөгжүүлэхэд энэ ном чухал гарын авлага болно. Өөрөөр хэлбэл бусдын оронд өөрийгөө тавьж, мэдрэмжийг ойлгох чадварыг энэ номоор хөгжүүлнэ.

**Дүрслэх урлаг:** Хүүхдүүдийг баяртай, гунигтай, уйтгартай гэх мэт сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн зураг зурах эсвэл ийм сэтгэл хөдлөл илэрхийлж буй мангасыг дуурайн зурах даалгавараар дүрийн сэтгэл хөдлөлийг зургаар илэрхийлэхэд тусална.

### Нэмэлт даалгавар

Жааз ашиглан мангасуудын сэтгэл хөдлөлийг дуурайн илэрхийлэх эсвэл жаазны ард очоод багшийн хэлсэн сэтгэл хөдлөлийг гаргах тоглоом тоглож болно.

Тоглоомоор дамжуулан сэтгэл хөдлөлийн илэрхийллийг гаргахад нь туслах.

24

*Түвшин ялгаатай хүүхдүүдтэй ажиллахад туслах нэмэлт даалгаврын санаа*

**ТУХАЙН СУРГУУЛИЙН 4 БАГШИЙГ БАЙНГИЙН СУРГАЛТАД ХАМРУУЛНА, ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ГАРЫН АВЛАГА ТАРААНА**

# +500

ХҮҮХЭДТЭЙ СУРГУУЛЬ

# +1000

ХҮҮХЭДТЭЙ СУРГУУЛЬ

НИЙТ ЗАРДАЛ

**150'750'00₮**

НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ ЗАРДАЛ

**сард 23,900**

НЭГ ХҮҮХДИЙН ЭЗЭМШИХ НОМЫН ТОО

**19 ном**

НИЙТ ЗАРДАЛ

**241,200,000₮**

НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ ЗАРДАЛ

**сард 20,427**

НЭГ ХҮҮХДИЙН ЭЗЭМШИХ НОМЫН ТОО

**16 ном**

4 БҮЛГИЙН 160 ХҮҮХЭД 4 НОМЫГ ХООРОНДОО СОЛИЛЦОН УНШИХ БОЛОМЖТОЙ. ИЙМД ХҮҮХДИЙН ТОО НЭМЭГДСЭН Ч НОМЫН ТОО НЭМЭГДЭХГҮЙ

| БҮЛЭГ | 1-р долоо хоног | 2-р долоо хоног | 3-р долоо хоног | 4-р долоо хоног |
|---|---|---|---|---|
| 3А анги | | | | |
| 3Б анги | | | | |
| 3В анги | | | | |
| 3Г анги | | | | |




ХҮҮХДИЙН ТОО НЭМЭГДЭХЭД 1 ХҮҮХДЭД НОГДОХ ЗАРДАЛ БУУРНА

| СУРГУУЛИЙН ХҮҮХДИЙН ТОО ХЭМЭГДЭХЭД | 1 ХҮҮХДЭД НОГДОХ НОМЫН ҮНЭ |
|---|---|
| 3000 хүүхэдтэй сургууль | ₮ 6'700 |
| 2500 хүүхэдтэй сургууль | ₮ 8'040 |
| 2200 хүүхэдтэй сургууль | ₮ 9'136 |
| 2000 хүүхэдтэй сургууль | ₮ 10'050 |
| 1800 хүүхэдтэй сургууль | ₮ 11'167 |
| 1500 хүүхэдтэй сургууль | ₮ 13'400 |

## НЭГ ХҮҮХЭД ЖИЛД 67 НОМ УНШИНА

Хөтөлбөрөөр
X 5
дахин хямд

| 67 НОМЫГ **СУРГУУЛЬ ДЭЭРЭЭ УНШИХАД** | 67 НОМЫГ **ХУВИАРАА ХУДАЛДАЖ АВБАЛ** |
|---|---|
| нэг хүүхдийн **жилд** төлөх номны мөнгө **241,200** | нэг хүүхдийн **жилд** төлөх номны мөнгө **1,206,000** |
| нэг хүүхдийн **сард** төлөх номны мөнгө **20,100** | нэг хүүхдийн **сард** төлөх номны мөнгө **100,500** |
| нэг хүүхэд **эзэмших** номын тоо **16** | нэг хүүхэд **эзэмших** номын тоо **67** |

СУЛ ТАЛ

- Гарын авлага байхгүй
- Номын унших цаг сургууль дээр гаргаж өгөхгүй
- Эцэг, эхэд нь ном унших, хэлэлцэх арга зүй дутмаг
- Уншсан номоо ярилцах, хэлэлцэх боломж, найзууд хомс
- Уншсан агуулгаа ойлгосон эсэхийг шалгах багш байхгүй

### НОМ БҮТЭХЭД ЯМАР ЗАРДАЛ ГАРДАГ ВЭ?

Үндсэн:

- Зохиогчийн эрхийн төлбөр
- Зургийн төлбөр
- Эх бэлтгэл, редакцын зардал
- Орчуулгын зардал
- Хэвлэлийн зардал
- НӨАТ ба бусад татвар

| Хэмнэх боломжтой бусад зардалд | | 20000 |
|---|---|---|
| • Номын дэлгүүрийн борлуулалтын шимтгэл | 20% | 4000 |
| • Тээвэр, түгээлтийн зардал | 0.5% | 100 |
| • Маркетингийн зардал | 3% | 600 |
| • Элэгдэл хорогдлын зардал | 0.1% | 20 |
| • Хадгалалтын зардал | 1% | 200 |
| Хэмнэх дүн: | | ***4920*** |

ЖИШЭЭ:


ХУЛГАЙЛАГДСАН муужгай,
өндөг дардаг МАТАР,
аврагдсан СУПЕР БААТРУУД,
мөн
авто уралдааны ИД ШИД
ДӨРВӨН СОЛИОТОЙ үлгэрийг
Winnie AND Wilbur
ВИННИ, ВИЛБЭР ХОЁРЫН АДАЛ ЯВДЛААС
NEPKO KidS
ORIGINAL ENGLISH LANGUAGE EDITION BY OXFORD UNIVERSITY PRESS
British School of Ulaanbaatar
RioTinto
Pizza Hut
TOMYO SCHOOL
ISBN 991951248-4
Winnie AND Wilbur ★ Цахилгаан ВИННИ
ЛОРА ӨВЕН, КОРКИ ПОЛ
NEPKO KidS
Winnie AND Wilbur
NEPKO KidS
ЛОРА ӨВЕН, КОРКИ ПОЛ
Цахилгаан ВИННИ
ДӨРВӨН ШИДЭТ ТҮҮХ

| Төслийн үе шат | No. | 1000 ном төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө | 2023 | 2024 | | | | | | | | | | | | 2025 | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 1 | 2 | 3 | 4 |
| **Судалгааны ажлууд** | 1 | Олон улсын уншлагын хөтөлбөрүүдийн судалгаа хийх, туршлага судлах | | | | | | | | | | | | | | | | | |
| | 2 | Хүүхдийн хөгжил, эзэмшвэл зохих мэдлэг, ур чадварын судалгаа хийх | | | | | | | | | | | | | | | | | |
| | 3 | Унших арга зүйн судалгаа хийх | | | | | | | | | | | | | | | | | |
| | 4 | 1000 номын ангиллыг тодорхойлж, эцэслэх | | | | | | | | | | | | | | | | | |
| | 5 | Номын судалгаа хийх | | | | | | | | | | | | | | | | | |
| | 6 | 1000 номын жагсаалтаа эцэслэх | | | | | | | | | | | | | | | | | |
| **Паблишинг, продакш ажлууд** | 7 | Хэвлэлийн төлөвлөгөө гаргах | | | | | | | | | | | | | | | | | |
| | 8 | Зохиогчийн эрхүүдийг судалж, авах | | | | | | | | | | | | | | | | | |
| | 9 | Орчуулгын номуудыг орчуулж эхлэх, үргэлжлэх | | | | | | | | | | | | | | | | | |
| | 10 | Эх бэлтгэлийн ажлууд эхлэх | | | | | | | | | | | | | | | | | |
| | 11 | Монгол контентын баг бүрдүүлэх | | | | | | | | | | | | | | | | | |
| | 12 | Монгол контент бүтээх ажлыг эхлүүлэх | | | | | | | | | | | | | | | | | |
| | 13 | Арга зүйчдийн баг бүрдүүлэх | | | | | | | | | | | | | | | | | |
| | 14 | Арга зүйчид номын гарын авлагуудыг боловсруулж эхлэх | | | | | | | | | | | | | | | | | |
| **Хөрөнгө босгох, хамтын ажиллагаатай холбоотой ажлууд** | 15 | Төслийн танилцуулга бэлдэх | | | | | | | | | | | | | | | | | |
| | 16 | Боломжит донор байгууллагуудтай уулзаж, төслөө танилцуулах | | | | | | | | | | | | | | | | | |
| | 17 | 2024 онд Хөтөлбөрт хамрагдах 10 сургуулийг тодорхойлох | | | | | | | | | | | | | | | | | |
| | 18 | 10 сургуультай гэрээ байгуулах | | | | | | | | | | | | | | | | | |
| **Хөгжүүлэлтийн ажил** | 19 | Онлайн платформ хөгжүүлэх | | | | | | | | | | | | | | | | | |
| **Хөтөлбөр албан ёсоор хэрэгжих** | 20 | 10 сургуулийн багш, номын санчдын сургалтын төлөвлөгөө, хуваарийг гаргах | | | | | | | | | | | | | | | | | |
| | 21 | Багш нарын сургалтыг эхлүүлэх | | | | | | | | | | | | | | | | | |
| | 22 | Сурагчдын унших чадварын болон ерөнхий мэдлэгийн түвшин тогтоох үнэлгээ хийнэ | | | | | | | | | | | | | | | | | |
| | 23 | Уншлагын хөтөлбөрийг албан ёсоор хэрэгжиж эхлэх | | | | | | | | | | | | | | | | | |
| | 24 | Явцын үнэлгээ хийх (улирал тутам) | | | | | | | | | | | | | | | | | |
| | 25 | Явцын тайлан гаргах | | | | | | | | | | | | | | | | | |
| | 26 | Жилийн эцсийн үнэлгээ хийх | | | | | | | | | | | | | | | | | |
| | 27 | Жилийн эцсийн тайлан гаргах | | | | | | | | | | | | | | | | | |
| | 28 | Хөтөлбөрийн хэрэгжилтийг сургуулийн удирдлагууд болон донор байгууллагуудад танилцуулах | | | | | | | | | | | | | | | | | |

## СУРГУУЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

| | **БАГА АНГИ**<br>1-5 дугаар анги | **ДУНД АНГИ**<br>6-9 дүгээр анги | **АХЛАХ АНГИ**<br>10-12 дугаар анги |
|---|---|---|---|
| **Уншлагын цаг** | 7 хоногт 2 цаг | 7 хоногт 2 цаг | 7 хоногт 2 цаг |
| **Уншлагын цагийг хариуцах** | **Бага ангийн багш / Номын санч** | **Сурагчдын удирдах зөвлөл** | **Сурагчдын удирдах зөвлөл** |
| **Үүрэг** | • Сургалтад хамрагдах<br>• Уншлага хийх<br>• Уншлагын явцыг бүртгэх, ахиц өөрчлөлтийг тэмдэглэх<br>• Үнэлгээг зохион байгуулах | • Сургалтад хамрагдах<br>• Уншлагын **өдөрлөг** зохион байгуулах<br>• Уншлага хийх<br>• Үнэлгээг зохион байгуулах | • Сургалтад хамрагдах<br>• Уншлагын **өдөрлөг** зохион байгуулах<br>• Уншлага хийх<br>• Үнэлгээг зохион байгуулах |
| **Урамшуулал** | • **Шилдэг уншигчийн үнэмлэх (бэлэг/ номын сангийн сарын эрх)**<br>• **Бүтээлч ангийн батламж (шөнийн хөтөлбөрт хамрагдах эрх)** | • **Шилдэг уншигчийн үнэмлэх (бэлэг/ номын сангийн сарын эрх)**<br>• **Бүтээлч ангийн батламж (шөнийн хөтөлбөрт хамрагдах эрх)** | • **Шилдэг уншигчийн үнэмлэх (бэлэг/ номын сангийн сарын эрх)**<br>• **Сайн дурын ажлын цагийг системд бүртгэх**<br>• **Oxford-ын цахим хөтөлбөрт үнэгүй хамрагдах эрх (English, IT, Leadership, Project management, Creative thinking etc.)**<br>• **Гадныг улс руу тэтгэлэгт хөтөлбөрт тодорхойлох** |

1000 НОМ

УНШЛАГЫН ХӨТӨЛБӨР

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА